



## **“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025.02.17

№ АЗТУЗ2025001

Улаанбаатар хот

### **КОМПАНИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН, ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭГ ДҮГНЭХ ТУХАЙ**

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, санал хураалтын дүн, “Алтайн Зам” ХК-ийн 2024 оны тайланг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.11 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагын танилцуулсан тайланг хангалттай гэж үзсүгэй.

**ХОЁР.** Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

**ГУРАВ.** Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнхөд даалгасугай.

**ДӨРӨВ.** Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөсөн болон тогтоосон цаг хугацаанд үнэн зөвөөр тайлагнан, журмын дагуу НББ-д тусган ажиллахыг Алтайн зам ХК / Б.Энхбат, Э.Өлзийхутаг/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**М.НЯМДАВАА**



## “АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025.02.17

№ АЗТУЗ2025002

Улаанбаатар хот

### НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

**ХОЁР.** Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, тайлагнахыг ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуунд даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

**М.НЯМДАВАА**



## **“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025.02.17

№ АЗТУЗ2025003

Улаанбаатар хот

### **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 60.1 дэх заалт, 76 дугаар зүйл, 76.1.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 04-ний Даваа гарагийн 15:00 цагт Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд ZOOM программ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулахаар товловсугай.

**ХОЁР.** Хурлаар хэлэлцэх асуудал болон хуралдааны дэгийг Тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.

**ГУРАВ.** Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Нямдавааг томилсугай.

**ДӨРӨВ.** Хурал зохион байгуулах болон тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

- |                   |                                       |
|-------------------|---------------------------------------|
| ➤ Комиссын дарга  | Э.Өлзийхутаг / Ерөнхий нягтлан бодогч |
| ➤ Комиссын гишүүн | Д.Дэлгэрсүрэн /Хүний нөөцийн менежер  |
| ➤ Комиссын гишүүн | Б.Бат-Эрдэнэ/ Ерөнхий менежер         |

**ТАВ.** Хуралд оролцох эрхтэй, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөр тасалбар болгож, олон нийтэд 2025 оны 03 сарын 15-ны өдөр мэдээлсүгэй.

**ЗУРГАА.** Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өгөх, хавсралт №2-д заагдсан баримт бичигтэй танилцуулах ажлыг 2025 оны 3 сарын 10-ны өдрөөс 2025 оны 3 сарын 14-ний өдрүүдэд хувьцаа эзэмшигч нарт хүндрэлгүйгээр, цахим хэлбэрээр танилцах боломжоор ханган ажиллахыг зохион байгуулах комисст даалгасугай.

**ДОЛОО.** Санал авах хуудасны загварыг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 880 тоот тогтоолоор баталсан журмын дагуу тогтоолын хавсралт №3-д зааснаар баталж, Хувьцаа эзэмшигчдийг эчнээ санал өгөх боломжоор хангах ажлыг зохион байгуулахыг ТУЗНБД Б.Буянзаяад үүрэг болгосугай.

**НАЙМ.** Эчнээ саналын хуудас хүлээн авах өдрийг 2025 оны 03 сарын 17-ны өдөр эхлүүлж 2025 оны 3 сарын 27-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

**ЕС.** Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу түгээхийг ТУЗНБД Б.Буянзаяад даалгасугай.

**АРАВ.** Хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчид болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, харилцагч брокерын үйлчилгээ үзүүлэгч компаниуд руу хүргүүлэн ажиллахыг Комисст даалгасугай.

**АРВАН НЭГ.** Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасан мэдээллийг

холбогдох этгээдүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг ТУЗНБД Б.Буянзаяад үүрэг болгосугай.

**АРВАН ХОЁР.** Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр ZOOM программ ашиглан хуралдуулах болсонтой холбогдуулан программын аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, төлбөрт үйлчилгээг сонгон, хувьцаа эзэмшигч нарт тухайн программын заавар, хуралдаанд оролцох болон санал өгөх зааварчилгааг нэг бүрчлэн өгч ажиллахыг Коммист даалгасугай.

**АРВАН ГУРАВ.** Хуралтай холбоотойгоор гарах зардлыг Компаниас гаргахыг Алтайн зам ХК-д зөвшөөрсүгэй.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**М.НЯМДАВАА**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТОВ

№	Хэлэлцэх асуудал	Хариуцан танилцуулах, гүйцэтгэх хүн	Шийдвэрийг төсөл	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх Ирцийг танилцуулах	ТУЗНБД Б.Буязаяа		15:00-15:30 ZOOM программыг нээж хувьцаа эзэмшигч нарт ID болон PASS кодыг илгээх
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон дэгийг танилцуулах	Хурлын дарга М.Нямдаваа		15:30-15:35
3	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуун	АЗХЭ2025001	15:35-16:35
4	Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай тогтоол	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх		
5	ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ТУЗ-ийн дарга М.Нямдаваа	АЗХЭ2025002	
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	Нэр дэвшүүлэх хорооны дарга С.Балжинням	АЗХЭ2025003	
7	Санал хураалт			16:35-16:50
8	Тооллогын комиссын тогтоол танилцуулах			16:50-17:00
9	Хурлыг хаах			17:00-17:10

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. 2024оны санхүүгийн тайлан
2. 2024 оны үйл ажиллагааны тайлан
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт
4. 2024 оны ТУЗ-ийн тогтоолууд
5. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
7. ТУЗ-ийн зардлын төсөв
8. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга
9. 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоол

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн овог \_\_\_\_\_
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр \_\_\_\_\_
3. Хувьцаа эзэмшигчийн нэр \_\_\_\_\_
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл \_\_\_\_\_
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар \_\_\_\_\_
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар \_\_\_\_\_
7. Санал өгөх хувьцааны тоо \_\_\_\_\_
8. Бүртгэсэн / брокер, дилер/ компанийн нэр \_\_\_\_\_
9. Брокерын овог, эр \_\_\_\_\_

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	АЗХЭ2025001 2024 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай			
2	АЗХЭ2025002 2024 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай			
3	АЗХЭ2025003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай			

Кумулатив аргаар санал өгөх (ТУЗ-ийн гишүүн сонгох)

ТУЗ-ийн гишүүдийн тоо	Нийт саналын эрхийн тоо	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид өгсөн саналын хуваарилалт					Хараат бус гишүүдэд нэр дэвшигчдэд өгсөн саналын хуваарилалт		
9									

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

**Санал авах хуудасны ашиглах санамж**

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
- Ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-70112251, 99992301, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Өдөр тутмын хэвлэлд өгөх зарын төсөл

## АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Алтайн Зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 04-ний Даваа гарагийн 15:00 цагт Алтайн зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд ZOOM программаар дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, Хүнсчдийн гудамж, Алтан тариа ХК-ийн байрны баруун талд, Алтайн Зам ХК-ийн байр

Хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нар нь 2025 оны 03 сарын 14-ний өдрийн дотор Хурал зохион байгуулах комиссын даргатай 99992301 дугаараар болон [secretaryaz@altainzam.mn](mailto:secretaryaz@altainzam.mn) цахим хаягаар холбогдож, хуралдаанд оролцох, санал өгөх заавар зааварчилгааг урьдчилан авна уу.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2025.03.10

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол хуваарилахгүй байх тухай тогтоолын танилцуулга
- ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай
- УБГ дээрх хувьцааны тоог залруулах тухай

Хурлын материал болон, шийдвэрийн төсөл холбогдох бусад баримттай ажлын өдрүүдэд 08:00-17:00 цагийн хооронд 99992301 дугаарын утсанд болон [secretaryaz@altainzam.mn](mailto:secretaryaz@altainzam.mn) цахим хаягаар холбогдож цахим шуудангаар дамжуулан авах бүрэн боломжтой.

Холбоо барих:

ТУЗНБД 99992301

Цахим шуудангийн хаяг: [secretaryaz@altainzam.mn](mailto:secretaryaz@altainzam.mn)

Цахим хуудас: [www.altainzam.mn](http://www.altainzam.mn)



**АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ**

Компанийн нэр	Алтайн Зам ХК
Хаяг, утас	Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан баг өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг	2025-04-04-ний 15:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	СХД, 4-р хороо Хүнсчдийн гудамж, Алтан Тариа ХК-ийн баруун талд Алтайн Зам ХК-ийн байр
Хурлын төрөл:	<b><u>ЭЭЛЖИТ</u></b>
	ээлжит бус
Хурал зарлагч	<b><u>ТУЗ</u></b>
	ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/
	Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2025-02-17
Олон нийгэд зарлах огноо	2025-02-21
Бүртгэх өдөр	2025-03-10
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2025-02-20
Хүргүүлсэн огноо	
Хурлын даргын нэр	М.Нямдаваа
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Э.Өлзийхутаг /Ерөнхий нягтлан бодогч/ Б.Бат-Эрдэнэ/ Ерөнхий менежер/ Д.Дэлгэрсүрэн /Хүний нөөцийн менежер/
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт, бичгийн хуудасны тоо	..... ширхэг ..... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

.....

/Э.Өлзийхутаг/